



I/2022


Тархаасан: 2022 оны 02 дугаар сарын 16



Үнэмлэхүй бага температур 2022 оны 1 дүгээр сард Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -45.8°C -д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2022 оны 1 дүгээр сард Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд $+4.8^{\circ}\text{C}$, үнэмлэхүй бага температур Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -45.8°C -д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР ($^{\circ}\text{C}$), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



¹ - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2022 оны 1 дүгээр сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Дорнод аймгийн Баян-Уул суманд 9.9 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Сэлэнгэ аймгийн Сайхан суманд 22м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2022 оны 1 дүгээр сард Мишээл экспо төв, Ургах наран хороолол, Богд хааны ордон музей, Баруун дөрвөн зам, Зуун айл, Цахилгаан станц, Баянхошуу, Амгалан, Таван буудал, Хайлааст, Нисэх, Тахилт, Зурагт орчимд $0.116\text{мг}/\text{м}^3$ - $0.765\text{мг}/\text{м}^3$ -д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас $0.066\text{мг}/\text{м}^3$ - $0.715\text{мг}/\text{м}^3$ -ээр буюу 2.3-15.3 дахин их байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2022 оны 1 дүгээр сард Хайлааст, Ургах наран хороолол, Нисэх, Богд хааны ордон музей, Таван буудал, Амгалан, 13-р хороолол, Тахилт, Баруун дөрвөн зам, Цахилгаан станц орчимд $0.067\text{мг}/\text{м}^3$ - $0.136\text{мг}/\text{м}^3$ -д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас $0.017\text{мг}/\text{м}^3$ - $0.086\text{мг}/\text{м}^3$ -ээр буюу 34.0 хувиас-2.7 дахин их байна.

Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2022 оны 1 дүгээр сард Мишээл экспо төв, Богд хааны ордон музей, Зурагт, Нисэх, Таван буудал, Ургах наран хороолол, Амгалан, Цахилгаан станц, 13-р хороолол, Тахилт, Баруун дөрвөн зам, Зуун айл, Хайлааст, Баянхошуу орчимд 0.126 мг/м³ – 0.510 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.026 мг/м³ – 0.410 мг/м³-ээр буюу 26.0 хувиас-5.1 дахин их байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM 10 тоосонцрын дундаж агууламж 2022 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.012 мг/м³ (8.6%)-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.008 мг/м³ (16.2%)-ээр их байсан бол PM 2.5 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.003 мг/м³ (2.6%)-ээр, хүхэрлэг хийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.053 мг/м³ (24.6%)-ээр тус тус бага байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мг/м³



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны 1 дүгээр сард 311 болж, өмнөх оны мөн үеэс 157 (33.5%) -оор буурсан байна. Газар хөдлөлт 2022 оны 1 дүгээр сард 7 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 150 (95.5%) -аар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны 1 дүгээр сард нийт 17 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 6 (54.5%) -аар нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны 1 дүгээр сард 1.3 тэрбум төгрөгийн хохирол учирч, 0.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I	2020 I	2021 I ²	2022 I ²	<u>2022 I²</u> 2021 I ²
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	460	385	468	311	66.5
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	3	2	157	7	4.5
Объектын түймрийн тоо	402	320	270	239	88.5
Амь насаа алдсан хүний тоо	12	14	11	17	154.5
Учирсан хохирол, тэрбум төгрөг	1.4	1.4	1.0	1.3	130.0
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	0.1	0.02	0.01	0.1	10.0 ¹

¹ - Дахин их

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол

Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл

Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг

Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр:

Цаг Уур, Орчны Шинжилгээний Газар,
Онцгой Байдлын Ерөнхий Газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 3 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

